



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/16/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.govisumveraudit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 7054-3156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayrg@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс аудит ХХК Утас: 77272708 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3.Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5Санхүүгийн тайлангийн тодруулга	11
Нийт үр дүн өмнөх оноос 3 дахин буюу 5,253.0 мянган төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	12
3 12	
3.9Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4.13өвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Х.БУЯНБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,453,601.00	37,084,760.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,600,000.00	2,400,000.00
31211	Төрийн сангийн харилцах	3,600,000.00	2,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37,853,601.00	34,684,760.00
35100	Түүхий эд материал	21,164,950.00	17,439,647.00
35110	Тусгай зориулалттай материал	21,164,950.00	17,439,647.00
35400	Хангамжийн материал	16,688,651.00	17,245,113.00
35410	Бичиг хэргийн материал	3,014,800.00	3,130,300.00
35420	Аж ахуйн материал	9,740,901.00	10,105,583.00
35440	Түлш, шатах тослох материал	80,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	378,500.00	629,980.00
35470	Бусад хангамжийн материал	3,474,450.00	3,379,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	268,606,636.09	279,113,380.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	268,606,636.09	279,113,380.75
39200	Биет хөрөнгө	217,403,469.51	230,832,922.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	199,835,000.00	199,835,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,044,784.67	-15,820,270.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,633,000.00	38,633,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,633,000.00	-38,633,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	53,600,370.07	74,138,522.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,024,651.57	-46,284,436.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,916,985.00	42,473,985.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,108,239.64	-24,513,667.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,700,000.00	2,700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,471,209.68	-1,696,209.68
39300	Биет бус хөрөнгө	51,203,166.58	48,280,458.18
39301	Програм хангамж	15,812,500.00	15,812,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,009,333.42	-5,932,041.82
39303	Бусад биет бус хөрөнгө	38,400,000.00	38,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	310,060,237.09	316,198,140.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	310,060,237.09	316,198,140.75
51	Засгийн газрын хувь оролцоо	310,060,237.09	316,198,140.75
51100	Засгийн газрын оруулсан капитал	132,190,076.00	132,190,076.00
51200	Хуримтлагдсан үр дүн	167,145,819.09	173,283,722.75
51210	Өмнөх үеийн үр дүн	165,060,849.68	167,145,819.09
51220	Тайлант үеийн үр дүн	2,084,969.41	6,137,903.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,724,342.00	10,724,342.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	310,060,237.09	316,198,140.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	422,735,570.00	431,373,495.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,909,170.00	33,760,775.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,909,170.00	33,760,775.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ	18,737,170.00	32,595,262.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - БМ	672,000.00	1,165,513.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,826,400.00	397,612,720.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,926,400.00	384,465,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,926,400.00	384,465,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,900,000.00	13,147,220.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	3,647,220.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,900,000.00	9,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	420,650,600.59	425,235,591.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,650,600.59	425,235,591.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,284,609.85	424,056,938.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,837,875.00	314,711,454.00
210101	Үндсэн цалин	304,711,875.00	314,625,720.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,000.00	85,734.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,592,034.26	42,017,675.54
210201	Тэтгэврийн даатгал	26,294,078.75	29,274,295.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,459,591.06	2,752,988.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,489.57	3,012,676.00
210204	Ажилгүйдлийн даатгал	614,897.52	634,328.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,148,977.36	6,343,388.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,199,606.00	17,308,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,999,506.00	2,376,777.00
210302	Түлш, халаалт	14,416,480.00	14,002,734.00
210303	Цэвэр, бохир ус	783,620.00	928,689.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,416,416.00	11,684,331.00
210401	Бичиг хэрэг	1,917,400.00	1,523,531.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,900.00	1,927,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,241,994.00	1,389,804.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,000.00	246,784.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	155,000.00	419,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,971,122.00	1,123,612.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,054,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	934,600.00	38,000.00

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлдхийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	934,600.00	38,000.00
2107	Томилолт, зочны зардал	857,700.00	235,600.00
210702	Дотоод албан томилолт	857,700.00	235,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,811,328.00	12,956,971.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	11,044,793.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,167,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	381,900.00	649,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,828.00	33,828.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	1,198,000.00
210807	Газрын төлбөр	8,400.00	8,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,635,050.59	25,104,707.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225,000.00	316,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,710,050.59	23,588,407.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,365,990.74	1,178,652.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,655,672.00	440,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,125,672.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	530,000.00	440,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,710,318.74	737,852.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,160,068.74	737,852.46
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	550,250.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,084,969.41	6,137,903.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,084,969.41	6,137,903.66

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,190,076.00	0.00	165,060,849.68	297,250,925.68
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	10,724,342.00	0.00	10,724,342.00
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,084,969.41	2,084,969.41
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,190,076.00	10,724,342.00	167,145,819.09	310,060,237.09
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,137,903.66	6,137,903.66
6	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	132,190,076.00	10,724,342.00	173,283,722.75	316,198,140.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	406,126,400.00	397,612,720.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,300,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,300,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,300,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	401,826,400.00	397,612,720.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,926,400.00	384,465,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,926,400.00	384,465,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,900,000.00	13,147,220.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	3,647,220.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,900,000.00	9,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,526,400.00	397,312,830.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,526,400.00	397,312,830.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,160,409.26	396,134,177.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,582,762.10	285,935,849.00
210101	Үндсэн цалин	209,513,562.10	212,877,048.00
210102	Нэмэгдэл	64,758,200.00	66,765,367.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,311,000.00	6,293,434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,817,677.16	38,643,833.54
210201	Тэтгэврийн даатгал	26,552,477.16	26,919,525.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,816,300.00	2,956,312.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,253,000.00	2,338,506.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563,300.00	584,126.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,632,600.00	5,845,364.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,199,606.00	17,308,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,999,506.00	2,376,777.00
210302	Түлш, халаалт	14,416,480.00	14,002,734.00
210303	Цэвэр, бохир ус	783,620.00	928,689.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,601,816.00	6,450,600.00
210401	Бичиг хэрэг	1,458,400.00	1,031,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,022,900.00	1,847,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,241,994.00	1,404,304.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,000.00	344,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,710,522.00	1,822,512.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	982,700.00	650,697.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	883,000.00	570,897.00
210604	Урсгал засвар	99,700.00	79,800.00
2107	Томилолт, зочны зардал	657,700.00	235,600.00
210702	Дотоод албан томилолт	657,700.00	235,600.00

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлдхийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,118,148.00	45,393,098.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,218,820.00	43,480,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,167,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	381,900.00	649,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,828.00	33,828.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	1,198,000.00
210807	Газрын төлбөр	8,400.00	8,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	1,516,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	1,200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	316,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,365,990.74	1,178,652.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,655,672.00	440,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,125,672.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	530,000.00	440,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,710,318.74	737,852.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,160,068.74	737,852.46
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	550,250.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,600,000.00	299,890.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	1,499,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,499,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,499,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,499,890.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-1,499,890.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,600,000.00	-1,200,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,600,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,600,000.00	2,400,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,465,500.00	383,727,647.54	737,852.46	99.81
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	384,024,700.00	383,286,847.54	737,852.46	99.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,628,000.00	285,935,849.00	692,151.00	99.76
210101	Үндсэн цалин	213,558,800.00	212,877,048.00	681,752.00	99.68
210102	Нэмэгдэл	64,758,200.00	66,765,367.00	2,007,167.00	103.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,311,000.00	6,293,434.00	2,017,566.00	75.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,644,900.00	38,643,833.54	1,066.46	100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,379,700.00	26,919,525.54	460,174.46	98.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,816,300.00	2,956,312.00	-140,012.00	104.97

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлдхийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,253,000.00	2,338,506.00	-85,506.00	103.80
210204	Ажилгүйдлийн даатгал	563,300.00	584,126.00	-20,826.00	103.70
210205	Эрүүл мэндийн даатгал	5,632,600.00	5,845,364.00	-212,764.00	103.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,308,200.00	17,308,200.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,763,700.00	2,376,777.00	-613,077.00	134.76
210302	Түлш, халаалт	13,904,400.00	14,002,734.00	-98,334.00	100.71
210303	Цэвэр, бохир ус	1,640,100.00	928,689.00	711,411.00	56.62
2104	Хангамж, бараа материалын зардал	5,282,600.00	5,282,600.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	735,600.00	783,800.00	-48,200.00	106.55
210402	Тээвэр, шатахуун	927,000.00	927,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,379,400.00	1,404,304.00	-24,904.00	101.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	309,100.00	344,984.00	-35,884.00	111.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,931,500.00	1,822,512.00	108,988.00	94.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,151,500.00	2,150,587.00	913.00	99.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,071,700.00	2,070,787.00	913.00	99.96
210604	Урсгал засвар	79,800.00	79,800.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	139,600.00	139,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	139,600.00	139,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,869,900.00	33,826,178.00	43,722.00	99.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,914,000.00	32,914,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	649,950.00	50.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,900.00	33,828.00	42,072.00	44.57
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	198,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	10,000.00	8,400.00	1,600.00	84.00
213	Урсгал шилжүүлэг	440,800.00	440,800.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	440,800.00	440,800.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,800.00	440,800.00	0.00	100.00
III	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	384,465,500.00	383,727,647.54	737,852.46	99.81
310001	Улсын төсвөөс санхүүжих	384,465,500.0	383,727,647.54	737,852.46	99.81
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	23		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	16	15		
620003	Үйлчлэх ажилтан	7	7		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	Нийт зарлага, цэвэр зээлийн дүн	13,147,220.00
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	13,147,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,168,000.00
210401	Бичиг хэрэг	248,000.00
210402	Тээвэр, шатахуун	920,000.00
2107	Томилолт, зочны зардал	96,000.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,566,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,566,920.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	316,300.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,147,220.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,147,220.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,647,220.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,500,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цахим төлбөрийн баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийг аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Монгол хүний олдмол, удамшиж буй халамж хүссэн “СЭТГЭЛГЭЭГ” өөрчилж “САНАА ЗӨВ” хөдөлмөрч монгол иргэнтэй болохыг эрхэмлэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.
Үүнд:

- ✚ Салбарын хууль тогтоомж бодлого хөтөлбөр, дүрэм журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлын манлайлал, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанрыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- ✚ Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, чанар үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- ✚ Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны соёл төлөвшүүлэх мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✚ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ✚ Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 424,035.5 мянган төгрөгний 2 хувиар буюу 8,481.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,337.9 мянган төгрөгөөр өссөн ба өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлтэй үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө/ахмадын сан/	3,600.0	2,400.0	(1,200.0)
Бараа материал	37,853.6	34,684.7	(3,168.8)
Үндсэн хөрөнгө	268,606.6	279,113.3	10,506.7
Нийт хөрөнгө	306,460.2	313,798.1	7,337.9
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	306,460.2	313,798.1	7,337.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	306,460.2	313,798.1	7,337.9

Бараа материалын дансны үлдэгдэл 34,684.7 мянган төгрөг болж 3,168.8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталж устгасантай холбоотой ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,602.2 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1,165.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 3,882.6 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 279,113.3 мянган төгрөг болж 10,506.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 1,499.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүйгээр 30,995.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 313,798.1 мянган төгрөг болж 7,337.9 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 2021 онд 431,373.5 мянган төгрөгийн орлого орж, тайлант хугацаанд 424,035.6 мянган төгрөгийн зардал гарч, үйл ажиллагааны үр дүн 7,337.9 мянган төгрөгийн ашигтай байна.

Үйл ажиллагааны орлого өмнөх оноос 2.0 хувь буюу 8,637.9 мянган төгрөгөөр өссөнийг орлого тус бүрийн үзүүлэлтээр авч үзэхэд өөрийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, орон нутгийн санхүүжилт нийт 23,098.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй, улсын төсвийн санхүүжилт 14,460.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үйл ажиллагааны зарлага өмнөх оноос 1.0 хувиар буюу 3,384.9 мянган төгрөгөөр өссөнийг зардлын ангилалаар авч үзэхэд бараа, ажил үйлчилгээний зардал 28,572.2

нэмэгдсэнтэй, урсгал шилжүүлэг 25,925.1 мянган төгрөгөөр багассантай холбоотой байна.

Нийт үр дүн өмнөх оноос 3 дахин буюу 5,253.0 мянган төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 512,961.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 137,904.1 мянган төгрөгөөр бууруулж 375,057.6 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 9,407.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 384,465.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 383,727.6 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос урсгал үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 383,727.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа ба батлагдсан төсөвт зардал 737.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалин хөлс НДШ-693,2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр-43.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал-0.9 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээрэнэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 13,147.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос хангамж материалын зардалд 1,168.0 мянган төгрөг, томилолтын зардалд 96.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 11,566.9 мянган төгрөгийг, үйлчилгээний бусад зардал-316.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Говьсүмбэр аймаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 139 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2021 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээллийг байршуулахаас 146 мэдээллийг байршуулсан ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 11,797.1 мянган төгрөгийн залруулга, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн ба хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,011.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 19,011.7 төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2021 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээллийг байршуулахаас 146 мэдээллийг байршуулсан ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах

2. Цахим төлбөрийн баримттай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Тайлант онд 21,938.2 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс цахим төлбөрийн системд 19,011.7 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шивээгүйг хянаж, залруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй, Батламж мэдэгдлийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэж заасныг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулж авах, татварын цахим системийн шивэлтэд хяналт тавьж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2	19,011.7							2	19,011.7